

МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БАТЛАХ ТУХАЙ ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор “2024 оныг Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг 2001 онд Улсын Их Хурлын 57 дугаар тогтоолоор батлан, мөрдүүлснээс хойш 23 жилийн хугацаа өнгөрч байна. Өнгөрсөн хугацаанд бүс нутаг төлөвлөлтийн онол, аргазүйд шилжилт хийгдэж “шинэ эдийн засаг-газарзүйн онол, кластерын онол, хөгжлийн туйл, өсөлтийн төвийн онол”-ууд орчин үеийн чиг хандлага болж байна.

Мөн өнгөрсөн хугацаанд Улаанбаатар хотод нийт хүн амын 48.9 хувь буюу 1.7 сая хүн амьдарч, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 70 хувь, худалдаа үйлчилгээний 84 хувь, их дээд сургуулийн 96 хувь нь төвлөрч, ДНБ-ий 63 хувь нь үйлдвэрлэгдэж Хот, хөдөөгийн хөгжил хэт ялгаатай болсон.

Иймд дэлхий дахинд баримталж буй ирээдүй хойч үедээ унаган байгалийг алдагдуулахгүй өвлүүлэх тогтвортой хөгжлийн үзэл санаа, орчин үеийн онолын чиг хандлага, хот, хөдөөгийн хөгжлийг тэнцвэржүүлэх практик хэрэгцээ шаардлагаас үүдэн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг шинэчлэн боловсруулаад байна.

Төслийг боловсруулахдаа олон улсын гео эдийн засаг, газарзүйн байршил, онцлог, нөөц, хүн амын нутагшил суурьшил, бүс нутгийн эдийн засгийн интеграцитай соёл, аялал жуулчлал, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хоршилт, төрөлжилт, дагалт бий болгох замаар уялдуулан хөгжүүлэх боломжийг харгалзан үзсэн болно.

Энэхүү үзэл баримтлалд Монгол Улсын хөгжлийг түргэтгэх эдийн засгийн арга хэрэгсэл болох бүсүүдийг тодорхойлж, тэдгээр бүсүүдийн тэргүүлэх чиглэл, эрхэм зорилгыг томъёолон, түүнд хүрэх эдийн засаг, санхүүгийн дэмжлэг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, орон зайн төлөвлөлт бүхий зорилтуудыг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан тодорхойллоо.

Дараах ажлын хэсгүүдийг байгуулж, холбогдох тооцоо, судалгааг хийж, санал авах хэлэлцүүлгийг улс, бүс, аймгуудын хэмжээнд зохион байгуулсан. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 165 дугаар захирамжаар анхны ажлын хэсгийг байгуулан 2023 он хүртэлх хугацаанд олон улсын байгууллагууд, эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдтэй хамтарсан 600 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажлын дэд хэсэг ажиллаж, 21 аймаг, нийслэлийн хэмжээнд санал авах хэлэлцүүлгийг 100 гаруй удаа зохион байгуулж, хэлэлцүүлгээс давхардсан тоогоор 1000 гаруй санал гарсныг нэгтгэн “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын төсөлд тусгасан.
- Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА) техник тусалцааны төсөл хэрэгжүүлж, орон зайн төлөвлөлтийн тооцоо судалгаа,

хувилбарыг боловсруулан Монгол Улсын Засгийн газарт хүлээлгэн өгснөөс холбогдох саналыг “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөл”-д тусгасан.

- Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар 2022-2023 онд хот хөдөөгийн сэргэлтийн ажлын хэсэг байгуулагдаж, “Монголын эдийн засгийн чуулган” мөн 21 аймаг, нийслэлд хөрөнгө оруулалтын форумыг зохион байгуулж “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын төсөлд олон нийтийн саналыг авсан.
- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан.
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар тогтоолоор Бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсронгуй болгох, Монгол Улсын эдийн засгийн бүсчлэлийг тогтоох асуудлаар эдийн засгийн форумыг бүсчлэн зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.
- “Бүсийн урьдчилсан хэлэлцүүлэг”-ийг Зүүн, Баруун, Хойд, Хангай, Төв, Говийн бүс бүрээр 2024 оны 01 дүгээр сард зохион байгуулж, нийт 700 орчим оролцогчдоос давхардсан тоогоор 440 гаруй санал зөвлөмж гарснаас холбогдох саналыг тусгасан.
- “Монголын эдийн засгийн чуулган – Бүсчилсэн хөгжил” зөвлөгөөнийг 2024 оны 02 дугаар сард зохион байгуулж, УИХ, ЗГ-ын гишүүд, яамдын төлөөлөл, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, ИТХ, олон улсын байгууллага, шинжлэх ухааны байгууллага, аж ахуйн нэгж, улс төрийн нам, эвслийн төлөөлөл, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагын 2,775 төлөөлөл оролцож, хэлэлцүүлгээс гарсан 1,200 орчим санал, зөвлөмжийг нэгтгэн боловсрууллаа.
- Мөн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл веб сайтаар дамжуулан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулсан.
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 11 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/09 дүгээр тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсэг гарсан нийт санал зөвлөмжийг хэлэлцэн, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд тусган эцэслэн боловсруулсан.

Бүсчилсэн хөгжлийн эрхэм зорилгыг “Үндэсний соёлоо дээдэлсэн, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагалт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, өрсөлдөх чадвартай бүс нутгуудыг харьцангуй тэнцвэртэйгээр хөгжүүлнэ.” гэж тодорхойллоо.

Тус үзэл баримтлалд 6 бүлэг, 1 эрхэм зорилго, 7 зорилго, 217 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсыг эдийн засгийн “Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын” гэсэн долоон бүсчлэлийн тогтолцоогоор хөгжүүлэхээр тодорхойллоо. Эдийн засгийн бүс бүрд хамаарах аймгуудын ерөнхий хуваарийг дараах байдлаар тогтоосон бөгөөд цаашид хөгжлийн тухайн үеийн нөхцөл шаардлагатай уялдуулан уян хатан өөрчилж болно. Үүнд:

- Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг;
- Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг;
- Хойд бүсэд: Булган, Орхон, Хөвсгөл аймаг;
- Төвийн бүсэд: Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг;
- Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг;
- Говийн бүсэд: Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймаг;
- Улаанбаатарын бүсэд: Улаанбаатар ба дагуул хот.

Монгол Улсын бүсчлэлтэй уялдуулан нийслэл, аймаг бүрд орон нутгийн хөгжлийн төв, тэдгээрт таталцах сум, сууринуудыг уян хатан өөрчилж байхаар тогтоосон болно.

Бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилтуудыг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

- бүс нутгийн хөгжлийн орчин үеийн онолын чиг хандлагад үндэслэж;
- бүс нутгийн онцлог, давуу талыг нээн илрүүлж;
- бүс, орон нутгийн эдийн засгийн чиг үүргийг оновчтой тодорхойлж;
- байгалийн нөөц баялгийг зохистой, өгөөжтэй, хүртээмжтэй ашиглаж, хамгаалж, нөхөн сэргээж;
- үйлдвэр, үйлчилгээг хоршилт, төрөлжилт, дагалт, кластерын бодлогоор дэмжиж;
- бүс орон нутагт өндөр технологи, инновацыг нэвтрүүлж;
- бүс дамнасан, салбар хоорондын уялдааг хангасан стратегийн төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж;
- улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг оновчтой хуваарилж;
- татвар, санхүүгийн ялгаатай бодлогыг хэрэгжүүлж;
- бүс нутгийн хөгжилд оролцогч талуудын хамтран ажиллах сонирхлыг дэмжиж;
- тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ, боомт, чөлөөт бүс, тусгай бүсийг хөгжүүлж;
- дэд бүтцийн нэгдсэн, ухаалаг сүлжээг байгуулж;
- бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэн, зах зээлийг тэлж,
- орчин үеийн шинэ суурьшлын бүс, хотуудыг байгуулж;
- бүс нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулж;
- орон нутагт ажиллаж, амьдрах, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн өрсөлдөх чадвартай бүс нутгийг хөгжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР